

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Арвайхээр

Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн  
вакцинаар дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар дархлаажуулах тухай” А/08 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт саа өвчнийг дэлхий нийтэд устгах зорилтын хүрээнд халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар 2016 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд төрсөн хүүхдүүдийг нөхөн дархлаажуулах арга хэмжээг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Нөхөн дархлаажуулалтыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/08 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтад заасан зааврын дагуу дархлаажуулан, товллын дархлаажуулалтын үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар дархлаажуулах товыг нэгдүгээр, нөхөн дархлаажуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг гуравдугаар, шатахууны хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Дархлаажуулалтын ач холбогдлын талаар хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэн, олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

ЭМГ-ын даргын 2021 оны 1-р сарын 12- ны  
өдрийн 4/02 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт




ХАЛДВАРТ СААГИЙН ЭСРЭГ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН  
ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ТОВ

	Нөхөн дархлаажуулах хугацаа		
	2021 оны 1 дүгээр сар	2021 оны 2 дугаар сар	2021 оны 3 дугаар сар
Дархлаажуулах нас	2016 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн хүүхдүүд (5 настай)	2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн хүүхдүүд (4 настай)	2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн хүүхдүүд (3 настай)

Тайлбар. Халдварт саагийн эсрэг хоёр цэнт (bOPV) вакцинд хамрагдсан хүүхэд



ЭМГ-ын даргын 2021 оны 1-р сарын 12-ны өдрийн 402 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт




НӨХӨН ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
<b>1. Бэлтгэл ажлууд</b>				
1.1	Харъяа нутаг дэвсгэрт оршин сууж байгаа 2016 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд төрсөн хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргах	01 дүгээр сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
1.2	Халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин, дагалдах хэрэгслийг татах авах	01 сарын 10-ны дотор	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба
1.3	Халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин, дагалдах хэрэгслийг хуваарилан, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх	01 сарын 15-ны дотор	Эрүүл мэндийн газар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ
1.4	Эрүүл мэндийн ажилтан халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины нөхөн дархлаажуулалтын талаар эцэх, эх, асран хамгаалагчдыг мэдээллээр хангах	01 дүгээр сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
<b>2. Халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах үйл ажиллагаа</b>				
2.1	2016 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн 5 настай хүүхдийг халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах	01 дүгээр сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
2.2	2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн 5 настай хүүхдийг халдварт сагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах	02 дугаар сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар

	сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн 4 настай хүүхдийг халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах		сум, өрхийн ЭМТ	
2.3	2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрсөн 3 настай хүүхдийг халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаар нөхөн дархлаажуулах	03 дугаар сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
2.4	Нөхөн дархлаажуулсан хүүхдийг дархжуулалтын анхан шатны бүртгэл болон цахим бүртгэлд бүртгэн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээний хамт мэдээллийн урсгалын дагуу мэдээлэх	2021 оны 1-3 дугаар сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
2.5	Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинаас хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах	2021 оны 1-3 дугаар сар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
2.6	Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины дараах ДДУХ-ийг журмын дагуу тандах, бүртгэх, хариу арга хэмжээ авах	01 дүгээр сараас эхлэн	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
2.7	Нөхөн дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйгээр хангах, сургах, явцын дэмжлэгт хяналт хийх	2021 оны 1-3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	ХӨСҮТ, Дархлаажуулалтын алба
2.8	Нөхөн дархлаажуулалтын мэдээг нэгтгэн ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлэх	2021 оны 1-3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ




ЭМГ-ын даргын 2021 оны 1-р сарын 12- ны  
өдрийн *А.О.* дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

№	Сумын нэр	2016 оны 2- 12 сард төрсөн	2017 онд төрсө н	2018 онд төрсө н	Нийт хамрагда х хүүхэд	Хуваарилсан	
						Халдварт саагийн идэвхгүйжүүлсэ н вакцин хүн тун	Тариу р
1	БаруунБаян-Улаан	81	66	48	195	210	210
2	Бат-Өлзий	155	186	141	482	530	530
3	Баянгол	70	81	68	219	240	240
4	Баян-Өндөр	71	60	47	178	200	200
5	Богд	133	125	76	334	360	360
6	Бүрд	43	41	48	132	140	140
7	Гучин-Ус	37	45	32	114	120	120
8	Зүйл	78	47	65	190	210	210
9	Зүүнбаян-Улаан	91	70	39	200	220	220
10	Нарийнтээл	65	70	57	192	210	210
11	Өлзийт	35	22	24	81	90	90
12	Сант	49	57	32	138	155	155
13	Тарагт	45	31	41	117	130	130
14	Төгрөг	51	52	34	137	150	150
15	Уянга	166	196	194	556	615	615
16	Хайрхандулаан	80	80	57	217	240	240
17	Хархорин	214	244	206	664	725	725
18	Хужирт	127	137	116	380	420	420
19	Нарны дөш	275	249	216	740	820	820
20	Уянсэтгэл	187	192	190	569	630	630
21	Түшигдөлгөөн	176	238	158	572	630	630
22	Эрүүл мэндийн газар	164	100	61	325	360	360
	<b>Нийт</b>	<b>2393</b>	<b>2389</b>	<b>1950</b>	<b>6732</b>	<b>7405</b>	<b>7405</b>

ЭМГ-ын даргын 2021 оны 1-р сарын 12-ны  
өдрийн 4/22 дугаар тушаалын  
дөрөвдүгээр хавсралт



ДАРХЛААЖУУЛАЛТЫН ШАТАХУУНЫ ХУВААРИЛАЛТЫН ТООЦОО

№	Сумын нэр	Нийт хамрагдах хүүхэд	Хуваарилсан шатахуун /төгрөг/
1	БаруунБаян-Улаан	195	50000
2	Бат-Өлзий	482	100000
3	Баянгол	219	60000
4	Баян-Өндөр	178	50000
5	Богд	334	90000
6	Бүрд	132	40000
7	Гучин-Ус	114	30000
8	Зүйл	190	50000
9	Зүүнбаян-Улаан	200	60000
10	Нарийнтээл	192	90000
11	Өлзийт	81	20000
12	Сант	138	40000
13	Тарагт	117	30000
14	Төгрөг	137	40000
15	Уянга	556	130000
16	Хайрхандулаан	217	60000
17	Хархорин	664	130000
18	Хужирт	380	100000
19	Нарны дөш	740	50000
20	Уянсэтгэл	569	40000
21	Түшигдөлгөөн	572	40000
22	Эрүүл мэндийн газар	325	
	<b>Нийт</b>	<b>6732</b>	<b>1300000</b>